



Аргачлалын тайлбар :

## ОРОН НУТГИЙН ТӨСӨВ

Төсвийн орлого, зарлагын тооцоог Олон Улсын Валютын Сангийн стандарт ангиллаар 1995 оны 10-р сараас эхлэн гаргаж байна. Төсвийн орлогын мэдээг аймгийн Татварын хэлтэс, төсвийн зарлага, санхүүжилтийн мэдээг СЭЗТС-ийн хэлтсээс гаргадаг.

Төсвийн орлогын мэдээг хэрэглэгчдэд илүү тодорхой болгох зорилгоор аймгийн нийт төсвийн орлого, үүнээс улсын төвлөрсөн төсөвт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөөний биелэлт, орон нутгийн төсөвт (аймгийн) төвлөрүүлэх орлогын төлөвлөгөөний биелэлт гэж салгаж харууллаа.

Төсвийн зарлагыг эдийн засгийн салбарын ангиллаар гаргаж, улсын төсвийн байгууллагууд, орон нутгийн төсвийн байгууллагууд гэж тус тусдаа гарсныг нэгтгэж орууллаа.

## ҮНЭ

Аймгийн төвийн хүнсний зах дээр борлогдож байгаа хөдөө аж ахуйн гаралтай хүнсний бүтээгдхүүн, ноос, ноолуур, арьс шир зэрэг зарим бүтээгдхүүний зах зээлийн дундаж үнийг харуулав.

Хэрэглээний үнийн индекс гэдэг нь өрх орлогоороо өөрсдийн хэрэгцээнд худалдан авсан, үйлчлүүлсэн хамгийн чухал, эн тэргүүний нийтлэг хэрэгцээтэй бараа, үйлчилгээний үнийн өөрчлөлтийг тэдгээрийн хэрэглээний зардалд эзлэх хувиар жигнэсэн дундаж юм.

2006 оноос эхлэн хэрэглээний сагсны нэр төрлийг шинэчилж 194 нэр төрөл болгож 2005 оны 12-р сарын үнээр суурилан ХҮИ-ийг тооцож байна.

## АЖ ҮЙЛДВЭР

Аж ахуйн нэгжүүдийг эдийн засгийн үйл ажиллагаар нь ангилахдаа НҮБ-ийн эдийн засгийн үйл ажиллагааны Олон улсын стандарт ангиллыг мөрдөж байна.

Аж үйлдвэрийн борлуулсан бүтээгдхүүн нь аж ахуйн нэгж, байгууллагын тайлангийн хугацаанд худалдсан буюу гадагш гүйцэтгэсэн ажил, үйлчилгээний хэмжээ юм.

Аж үйлдвэрийн нийт бүтээгдхүүний өсөлтийг гол нэр төрлийн бүтээгдхүүнийг 2000 оны зэрэгцүүлэх үнээр үнэлж тодорхойлсон болно.

Гол нэр төрлийн бүтээгдхүүний үйлдвэрлэл нь тухайн бүтээгдхүүний үйлдвэрлэлийн биет хэмжээг харуулна.

## ХӨДӨЛМӨР

Ажилгүйчүүдийн тоонд олон улсын стандарт ангиллын дагуу Монгол улсын хуулиар зөвшөөрөгдсөн хөдөлмөрлөх насны, хөдөлмөр эрхлэх чадвартай, цалин хөлстэй ажил болон хувиараа хөдөлмөр эрхэлдэггүй, тухайн үед ажиллахад бэлэн, цалин хөлстэй ажил идэвхитэй эрж, хайж байгаа хөдөлмөр эрхлэлтийн албанд бүртгүүлсэн хүмүүс орно.

## ЭРҮҮЛ МЭНД

Нялхсын нас баралт ( 1 хүртэл насны 1000 хүүхдэд ногдох)- ыг тухайн үед 1 хүртэлх насны нас барсан хүүхдийн тоог тухайн үед амьд төрсөн хүүхдийн тоонд харьцуулж тодорхойлдог.

## ГЭМТ ХЭРЭГ

18 ба түүнээс дээш насны 10000 хүнд ногдох бүртгэгдсэн гэмт хэргийн тоог гаргахдаа нийт бүртгэгдсэн гэмт хэргийн тоог жилийн дундаж 18 ба



түүнээс дээш насны хүн амд харьцуулан тооцно.

## ХАА-Н САЛБАР

Аймгийн ИТХ-ын 2002 оны ээлжит 8-р хуралдаанаар баталсан бүсүүд:

Баруун бүс : Завхан, Наранбулаг, Өлгий, Өмнөговь, Тариалан, Ховд

Хойт бүс : Бөхмөрөн, Давст, Сагил, Түргэн

Зүүн бүс : Зүүнговь, Малчин, Тэс, Хяргас

Өмнөт бүс : Баруунтуруун, Зүүнхангай, Өндөрхангай, Цагаанхайрхан

Төвийн бүс: Улаангом хот

## ТЭМДЭГЛЭГЭЭНИЙ ТАЙЛБАР :

1. Саруудыг ром тоогоор тэмдэглэв. ( I, II, III, IV, V..... г.м )  
I-XII жилийн эхний тухайн сарыг оруулсан өсөн нэмэгдэх дүнг харуулав.

2. Дараахь тэмдэглэлүүдийг ашиглав :

... мэдээлэл байхгүй  
**0.0** маш бага тоо  
- гүйцэтгэл байхгүй  
Д - дахин

3. Орон дэвшүүлэлтээс хамаарч зарим үзүүлэлтийн нийлбэр нь дүнтэйгээ, бүтцийг хувиар илэрхийлэхэд 100 хувиас бага зэрэг зөрөх тохиолдол байж болно.

## Аймгийн эдийн, нийгмийн үндсэн үзүүлэлт 2008 онд

Аймгийн Дотоодын нийт бүтээгдхүүний 70 гаруй хувийг үйлдвэрлэдэг ХАА-н салбар, үүний дотроос МАА-н салбарт багагүй хүндрэл, бэрхшээл гарч, өвлийн улирал хэт хүйтэн, удаан үргэлжилж, малын идэш тэжээл хомсдож, хаварт нь хүчтэй цасан болон шороон шуурга болж эрсдэл ихтэй байсны улмаас ХАА-н салбарын тооллогын дүнгээр оны эцэст 2499.3 мянган толгой мал, үүний дотор 16.0 мянган тэмээ, 79.3 мянган адуу, 118.2 мянган үхэр, 1215.0 мянган хонь, 1070.9 мянган ямаатай болж өмнөх оноосоо 154.2 мянган толгойгоор, таван төрөлдөө буурсан байна.

Том мал, төлийн хорогдол өнгөрсөн оноос нэмэгдсэнээс шалтгаалж бойжсон төлийн тоо 153.6 мянгаар буурч, 210.9 мянган төл, 223.7 мянган том мал зүй бусаар хорогдсон нь 2007 оныхоос 3.6 - 4.7 дахин нэмэгдсэн байна.

2007 онтой харьцуулахад 100 хүртэл малтай өрхийн эзлэх хувийн жин 1.6 пунктээр, 101-200 хүртэл малтай өрхийн эзлэх хувийн жин 0.1 пунктээр нэмэгдэж малтай нийт өрхийн 67.8 хувь нь 200 хүртэл малтай өрхүүд эзлэх боллоо.

Аймгийн хэмжээгээр 2008 онд 2.2 мянган га д үр тариа, 225.3 га-д төмс, 167.9 га-д хүнсний ногоо тариалж, 3.1 мянган тн үр тариа, 2.3 мянган тн төмс, 1.8 мянган тн хүнсний ногоо хураан авсан нь 2007 оноос тариалсан үр тариа 658.5, төмс хүнсний ногоо 84 га-аар, хураан авсан үр тариа 1001 тн-оор, төмс 360.6, хүнсний ногоо 334 тн-оор тус тус нэмэгдсэн байна.

Аж үйлдвэрийн салбарын бүтээгдэхүүний үйлдвэрлэл 2005 оны зэрэгцүүлэх үнээр 4.3 тэрбум төгрөг болж өнгөрсөн оны мөн үеийнхээс 4.0 хувиар буюу 166.2 сая төгрөгөөр өссөн байна.



Боловсруулах салбарын үйлдвэрлэл 14.0 хувиар өсч, салбарын нийт өсөлтийг хангаж, аж үйлдвэрийн салбарт эзлэх байр суурь нь нэмэгдэн тус салбартаа 63.6 хувийг эзлэх болж 2007 оноосоо 6.8 пунктээр өсч, шинээр 5 нэр төрлийн бүтээгдхүүнийг үйлдвэрлэн зах зээлд гаргаж байна.

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ тариф 2008 оны 12-р сард оны эхнээс 24.6 хувь, суурь он буюу 2005 оноос 65.7 хувь, өмнөх сараасаа 1.5 хувиар тус тус өслөө.

Оны эхнээс бүх барааны бүлгийн үнэ, тариф 5.3 - 52.6 өссөн бөгөөд ялангуяа хүнсний барааны бүлгийн үнэ 35.8 хувь, согтууруулах ундаа, тамхины бүлгийн үнэ 19.2 хувиар, хувцас, бөс бараа, гутлын бүлгийн үнэ 10.0 хувиар, гэр ахуйн тавилга, гэр ахуйн барааны бүлгийн үнэ тариф 32.4, орон сууц, цахилгаан, түлшний бүлгийн үнэ тариф 26.9 хувь, эм тарианы бүлгийн үнэ 52.6, тээврийн үйлчилгээний бүлгийн үнэ 20.4, боловсролын бараа, үйлчилгээний үнэ 11.5, амралт, чөлөөт цагт зориулсан барааны бүлгийн үнэ 27.6, бусад бараа үйлчилгээний үнэ тариф 25.8, зочид буудал, нийтийн хоолны бүлгийн үнэ тариф 5.3 хувиар тус тус өслөө.

Жилийн 12 сарын 5 сард нь хэрэглээний бараа үйлчилгээний үнэ тариф өсч, бусад саруудад буурсан байна. Өнгөрсөн онд хамгийн өндөр өсөлттэй сардаа 10.7 хувь хүрч байсан бол энэ онд 10.2 хувьд хүрсэн байна.

Төсвийн нийт зарлагын 16.2 хувийг аймаг өөрийн орлогоороо бүрдүүлж аймгийн төсвийн орлогын төлөвлөгөөг 29.6 хувиар буюу 897.8 сая төгрөгөөр давуулан биелүүллээ.

Аймгийн төсвийн зарлагад эзлэх орлогын хувь хэмжээ 2005 оноос 0.9, 2006 оноос 0.1 пунктээр буурч, 2007 оныхоос 1.1 хувиар нэмэгдсэн байна. Аймгийн төсөв өглөггүй, 2.5 сая төгрөгийн авлагатай байж авлагын хэмжээ 2007 оноос 14.5 сая төгрөгөөр буурсан байна.

Банкны системийн хэмжээгээр 28.3 тэрбум төгрөгийн зээлийн өрийн үлдэгдэлтэй байж 2007 оноос 11.1 хувиар буюу 2.8 тэрбум төгрөгөөр өссөн байна. Иргэдийн хадгаламж 2007 оноос 471.7 сая төгрөгөөр буурлаа.

Барилгын салбарт 12.1 тэрбум төгрөгийн БУИЗ-ын ажил гүйцэтгэсэн нь өнгөрсөн оны мөн үеэс оны үнээр 3.2 пунктээр, инфляциар засварласанаар 22.3 хувиар буурсан байна.

2008 онд 3.3 тэрбум төгрөгийн ҮФ бүхий 22 объектыг ашиглалтанд оруулсан нь өнгөрсөн оноосоо үндсэн фондын хэмжээ 2 дахин, объектын тоо 69.2 хувиар тус тус өслөө.

**Аймгийн суурин хүн ам оны эцэст 77.2 мянга болж өнгөрсөн оноосоо 2.9 хувиар буюу 2.3 мянган хүнээр буурсан байна.**

2324 хүүхэд төрж, 482 хүн нас барж 2007 оноос төрөлт 349-өөр нэмэгдэж, нас баралт 62-оор буурлаа.

1000 хүнд 30 төрөлт, 6 нас баралт, 23.5 цэвэр өсөлт ноогдож 2007 оноос төрөлт 6-аар, цэвэр өсөлт 5.8 промилээр нэмэгдсэн байна. Хэдийгээр нас баралтын түвшин хэвийн, төрөлт ихээхэн нэмэгдсэн боловч аймгаас гадагш шилжих хөдөлгөөн зогсолтгүй үргэлжилж улмаар сүүлийн жилд өмнөх 3 жилийн дунджаас 87.3 хувиар нэмэгдсэнээс шалтгаалж хүн амын тоо өнгөрсөн оноос 2.3 мянгаар буурлаа.

0-1 насны хүүхдийн эндэгдлийн түвшин 13 промилээр буурч, халдварт өвчний гаралт 176 хүнээр буюу 24.1 хувиар нэмэгдэж, эхийн эндэгдэл 1 гарлаа.

Аймгийн хэмжээнд 130 бүтэн өнчин хүүхэд, 2148 хагас өнчин хүүхэд, 3577 өрх толгойлон гэр бүлгүй амьдарч байгаа хүн, 2608 хөгжлийн бэрхшээлтэй хүн байгаа бөгөөд 8 ба түүнээс дээш ам бүлтэй 620 өрх байна.

ЕБС-ийн өдрийн ангид 20.4 мянган охид, хөвгүүд суралцаж



суралцагчдын тоо 2007 оноос 0.1 мянган хүүхдээр буурсан байна.

XXY ний хэлтэст бүртгэлтэй ажилгүйчүүдийн тоо урьдчилсан гүйцэтгэлээр 1404 болж өнгөрсөн оноосоо 59.5 хувиар өслөө. 1447 иргэн ажилгүйчүүдэд шинээр бүртгүүлж, 773 бүртгэлтэй ажилгүйчүүд ажилд зуучлагдан оржээ.


2008 онд 463 гэмт хэрэг гарч 2007 оноос 27.5 хувиар буюу 100 тохиолдлоор өссөн байна. Гэмт хэргийн дотроос хүний амь бие, эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг 52.2, хүүхэд гэр бүл, нийгмийн ёс суртахууны эсрэг гэмт хэрэг 28.6 хувиар, дээрэм 75.0 хувиар, залилан 2.5 дахин, завших, үрэгдүүлэх 2.0 дахин, нийгмийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг 5.9 хувиар, хүн амын эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг 2.5 дахин, тээврийн хэрэгслийн ХАБ, ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг 31.3 хувиар тус тус өссөн байна.

## ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ОРЛОГО

Улсын төвлөрсөн төсвийн шилжүүлэг, дэмжлэгийг оруулан тооцсоноор 2008 онд аймгийн төсөвт 4269.3 сая төгрөгийн орлого орохоос 4891.5 сая төгрөгийн орлого орж төлөвлөгөө 14.6 хувиар буюу 622.2 сая төгрөгөөр давж биелэгдлээ.

Төсвийн урсгал орлогын төлөвлөгөө 49.2 хувиар, тусламжийн орлогын төлөвлөгөө 7.5 хувиар тус тус давж биеллээ.

Төсвийн орлогын өсөлт, бууралт, онуудаар



Улсын төвлөрсөн төсөвт 2.3 тэрбум төгрөгийг татвар, орлогын хэлбэрээр төвлөрүүлэхээс 2.8 тэрбум төгрөг төвлөрүүлж төлөвлөгөө 23.5 хувиар буюу 0.5 тэрбум төгрөгөөр давж биелсэн байна. Аймгийн төсөвт 722.1 сая төгрөгийн татварын орлого төвлөрүүлэхээс 1077.4 сая төгрөгийн орлого төвлөрүүлж төлөвлөгөөг 149.2 хувиар биелүүлж, 355.3 сая төгрөгөөр давууллаа.

Өмнөх 2007 онтой харьцуулбал аймгийн төсвийн орлого 57.5 хувиар буюу 1.4 тэрбум төгрөгөөр өсч, үүний дотроос улсын төвлөрсөн төсөвт төвлөрүүлэх орлого 60.9 хувиар буюу 1.1 тэрбум төгрөгөөр, аймгийн төвлөрүүлэх орлого 49.2 хувиар буюу 355.4 сая төгрөгөөр тус тус өссөн байна.

2008 онд улсын төвлөрсөн төсөвт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөөнөөс онцгой албан татварын төлөвлөгөө 0.8 хувиар буюу хамгийн бага хувиар давж биелэгдэн бусад татварын төрлүүд 22.0 - 37.5 хувиар давсан байна. Эдгээр орлогын гүйцэтгэлүүд өнгөрсөн оны түвшнээс ч 13.0 хувиас – 2.2 дахин илүү байна.

2008 онд аймагт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөөний биелэлтийг гол нэр төрлөөр авч хүү торгуулийн орлогын төлөвлөгөө 25.5 хувиар тасарч бусад бүх нэр төрөлдөө давж биелсэн байна.


Өнгөрсөн 2007 оны гүйцэтгэлтэй харьцуулбал ашигт малтмалын нөөцийн төлбөр 5.4, түгээмэл тархацтай ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр 39.5 хувиар тус тус бага, бусад төрөлдөө 3.2 – 67 хувиар илүү байна.

Татварын орлогын төлөвлөгөө бүх сумдууд биелүүлсэн байна.

Аймгийн төсвийн орлогын 78.0 хувийг тусламжийн орлогоор, 5.4 хувийг орлогын албан татвараар, 2.9 хувийг өмчийн албан татвараар, 11.8 хувийг бусад албан татвараар, 1.9 хувийг



татварын бус орлогоор тус тус бүрдүүлсэн байна.



Аймгийн төсвийн зарлагад орлогын эзлэх хувь 16.2 хувь болсон нь 2007 оныхоос 1.1 пунктээр илүү, 2006 оныхоос 0.1 пунктээр, 2005 оныхоос 0.9 пунктээр тус тус бага байна.



2004 оныг суурь болгон харьцуулж үзвэл аймгийн төсвийн орлого 2.5 дахин өсч байхад төсвийн зарлага 3.2 дахин өсч байна.

Төсвийн орлого, зарлагын өсөлт, 2004 I-XII = 100 %

	2004 I-XII	2005 I-XII	2006 I-XII	2007 I-XII	2008 I-XII
Орлого	100.0	89.3	105.5	157.3	247.8
Зарлага	100.0	110.2	136.6	219.4	322.2

### ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ЗАРЛАГА


Орон нутгийн төсвийн болон улсын төсвийн байгууллагуудын дүнгээр 24.2 тэрбум төгрөгийг урсгал зардалд зарцуулсан нь өнгөрсөн оны мөн үеэс 46.9 хувиар буюу 7.7 тэрбум төгрөгөөр илүү байна. Нийт зарлагын 57.4 хувийг цалин хөлсөнд, 5.5 хувийг эрүүл мэнд, нийгмийн даатгалын шимтгэлд, 31.9 хувийг бусад зардалд, 1.9 хувийг урсгал шилжүүлэг, 3.4 хувийг хөрөнгийн зардалд зориулан зарцууллаа.

Өнгөрсөн оны мөн үеэс цалингийн зардлын эзлэх хувь 14.0 пунктээр өсч, хөрөнгө оруулалтын


зардлын эзлэх хувь 0.9 пунктээр, бусад зардлын эзлэх хувь 7.9 пунктээр, эрүүл мэнд, нийгмийн даатгалын шимтгэлийн зардлын эзлэх хувь 5.3 пунктээр тус тус буурсан байна.



Төсвийн зардлын 25.1 хувийг төрийн үйлчилгээ, нийгмийн хэв журам, аюулгүй байдлын үйл ажиллагаанд, 48.0 хувийг боловсрол, 23.1 хувийг эрүүл мэндийн салбарт, 0.7 хувийг нийгмийн даатгал, халамжийн үйл ажиллагаанд, 0.7 хувийг ХАА-н салбарт зориулан зарцууллаа.



Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад төрийн үйлчилгээний салбарт зориулсан зардын эзлэх хувь 0.2 пунктээр, хөдөө аж ахуйн салбарын эзлэх хувь 0.8 пунктээр буурч, эрүүл мэндийн салбарынх 0.1 пунктээр өссөн байна.




Төсөвт 178 байгууллагуудад 4.0 мянган хүн ажиллаж, ажиллагсдын тоо өнгөрсөн оны мөн үеийнхээс 16.6 хувиар өслөө.

### ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГУУДЫН ӨГЛӨГ, АВЛАГА

Энэ оны 11 –р сарын эцэст үүсээд байсан 113.5 сая төгрөгийн өглөгийг бүрэн барагдуулж оны эцэст өргүй төсвийн гарлаа.

2008 онд 2.5 сая төгрөгийн авлагатай гарсныг 2007 оны харьцуулбал авлага 85.3 хувиар буюу 14.5 сая төгрөгөөр буурсан байна.


Төсөвт байгууллагын өглөг, авлага, сая төг




### Хэрэглээний үнийн индекс

2008 оны 12-р сард судлагдаж буй 194 өргөн хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ тариф өмнөх оны мөн үе буюу өнгөрсөн оны жилийн эцсээс 24.6, суурь оноос 65.7, хувь өсч, өмнөх сараас 1.5 хувиар буурчээ.

Өмнөх сараас мах махан бүтээгдэхүүний дэд бүлгийн үнэ 5.9, жимс, жимсгэний дэд бүлгийн үнэ 1.2, түлшний дэд бүлгийн үнэ 10.3, тээврийн бүлгийн үнэ 13.9 тус тус буурсан нь үнийн ерөнхий индекс буурахад нөлөөллөө. Хүнсний ногооны дэд бүлгийн үнэ 1.3, хувцас бөс бараа гутлын бүлгийн үнэ 2, гэр ахуйн барааны бүлгийн үнэ 0.5 хувь өсч, бусад бүлгийн үнэ тогтвортой байлаа.



Сарын инфляцийн түвшин



Сар бүрийн үнийн өсөлтийг харвал 5-р сард хамгийн их өсөлттэй /10.2/, 12-р сард хамгийн их бууралттай /-1.5/ байлаа. Өмнөх сараас 4 нэр төрлийн бүтээгдэхүүний үнэ 50-500 төгрөгөөр өсч, 19 нэр төрлийн бүтээгдэхүүний үнэ 50-13000 төгрөгөөр буурчээ.

Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулснаар барааны бүлгүүдээр үнийн өөрчлөлтийг тооцож үзвэл :

Хүнсний бараа, ундаа усны бүлгийн үнэ 35.8 хувь өссөн нь талх гурил будааны бүлгийн үнэ 45.0 %, мах махан бүтээгдэхүүний бүлгийн үнэ 18.8 %, сүү сүүн бүтээгдэхүүний бүлгийн үнэ 21.0 %, төрөл бүрийн өөх тосны бүлгийн үнэ 11.2 %, жимс, жимсгэний бүлгийн үнэ 35.0 %, хүнсний ногооны бүлгийн үнэ 34.6 %, сахар чихрийн бүлгийн үнэ 38.7 %, хүнсний бусад бүтээгдэхүүний бүлгийн үнэ 24.5 %, ундаа усны бүлгийн үнэ 30.3 % өссөнтэй холбоотой байна.

Согтууруулах ундаа, тамхины бүлгийн үнэ дүнгээрээ 19.2 % өссөн нь согтууруулах ундааны бүлгийн үнэ 25.0, тамхины бүлгийн үнэ 7 % өссөнтэй холбоотой байна.

Хувцас, гутал, бөс барааны бүлгийн үнэ дүнгээрээ 10.0 хувь өссөн нь хөвөн бөс барааны бүлгийн үнэ 10.1, бүх төрлийн хувцасны дэд бүлгийн үнэ 15.7 % үүнээс эрэгтэй болон хувцасны үнэ 11.8 %, эмэгтэй болон хувцасны үнэ 12.8 %, хүүхдийн хувцасны үнэ 21.4 %, жижиг эдлэл хэрэгслийн бүлгийн үнэ 17.1 %, гутлыг бүлгийн үнэ 2.3 хувь өссөнтэй холбоотой байна.



Орон сууц, ус цахилгаан түлш 26.9 %

Орон сууц, түлш цахилгааны бүлгийн үнэ дүнгээрээ 26.9 хувь өссөн нь орон сууцны техникийн болон засварын үйл ажиллагааны бүлгийн үнэ 32.8 %, усан хангамжийн бүлгийн үнэ 43.2 %, цахилгаан, хийн болон бусад түлшний бүлгийн үнэ 23.1 % өссөнтэй холбоотой байна.

Гэр ахуйн бараа, тавилга 32.4 %

Гэр ахуйн бараа, тавилганы бүлгийн үнэ дүнгээрээ 32.4 хувь өссөн нь гэрийн тавилганы бүлгийн үнэ 26.4 % цахилгаан барааны бүлгийн үнэ 55.7 %, гэр ахуйн шилэн эдлэл, сав суулганы барааны бүлгийн үнэ 42.3 %, өмчлөх, нэмэлт эдлэлийн үнэ 21.1 %, цэвэрлэгээний болон бусад жижиг барааны бүлгийн үнэ 32.4 % өссөнтэй холбоотой байна.

Эм тариа эмнэлгийн үйлчилгээ 52.6 %

Эм тариа, эмнэлгийн үйлчилгээний бүлгийн үнэ дүнгээрээ 52.6 % өссөн нь эм тарианы дэд бүлгийн үнэ 31.9 %, амбулаторийн үйлчилгээний үнэ 2 дахин, эмнэлэгт хэвтэж эмчлүүлсний үйлчилгээ 3 дахин өссөнтэй холбоотой байна.

Тазвэр 20.4 %

Тазвэрийн бүлгийн үнэ дүнгээрээ 20.4 % өссөн нь тазвэрийн хэрс-глийн засвар үйлчилгээний дэд бүлгийн 21.6 %, тазвэрийн үйлчилгээний бүлгийн үнэ 20.0 % өссөнтэй холбоотой байна.

Амралт чөлөөт цаг соёлын үйлчилгээ 27.6 %

Амралт чөлөөт цаг соёлын үйлчилгээний бүлгийн үнэ 27.6 % өссөн нь дуу дүрс гэрэл зургийн бүлгийн үнэ 43.3 % ном бичгийн хэрс-глийн үнэ 20.3 хувь өссөнтэй холбоотой байна.

Боловсролын үйлчилгээ 11.5 %

Боловсролын үйлчилгээний бүлгийн үнэ дүнгээрээ 11.5 % өссөн нь их дээд сургуулийн төлбөр 11.5 хувиар өссөнтэй холбоотой байна.

ЗБ нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээ 5.3 %

Зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээний бүлгийн үнэ 5.3 % өссөн нь нийтийн хоолны үйлчилгээний дэд бүлгийн үнэ 70.9 хувь өссөнтэй холбоотой байна.

Бусад бараа үйлчилгээ 25.8 %

Бусад бараа үйлчилгээний бүлгийн үнэ дүнгээрээ 25.8 % өссөн нь хувь хүнд хандсан үйлчилгээ 33.3 %, хувь хүний эд зүйл, хэрэглэлийн дэд бүлгийн үнэ 55.6 % өссөнтэй холбоотой байна.

**Мөнгө, зээл**

Монгол банкны эх үүсвэрээр 18.1 тэрбум төгрөг зузаатгалаар авч, 136.4 тэрбум төгрөг гүйлгээнд гаргаснаас 126.8 тэрбум төгрөгийг буюу гаргасан мөнгөний 93.0 хувийг эргүүлэн татсан байна.

2007 онтой харьцуулахад гүйлгээнд гаргасан мөнгө 1.3 тэрбум төгрөг буюу 1.0 хувиар, гүйлгээнээс татсан мөнгө 9.6 тэрбум төгрөг буюу 8.2 хувиар тус тус өсч, зузаатгалаар авсан мөнгө 3.4 сая төгрөгөөр буурсан байна.

Банкны системийн хэмжээгээр банкны зээлийн өрийн үлдэгдэл 28.3 тэрбум төгрөг болж өмнөх сараасаа 2.9 сая төгрөгөөр буурлаа.

Нийт зээлийн 1.1 хувь нь буюу 320.6 сая төгрөгийн зээл хугацаа хэтэрсэн, 98.9 хувь нь хэвийн зээл байна.

2007 оноос нийт зээлийн өрийн үлдэгдэл 11.1 хувиар, хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэл 2.2 дахин өсчээ.

155.3 сая төгрөгийн найдваргүй зээл байгаа нь өнгөрсөн оноос 62.7 хувиар өссөн бөгөөд нийт зээлийн өрийн үлдэгдлийн 0.5 хувь, хугацаа хэтэрсэн зээлийн 48.4 хувийг эзэлж байна.


Зээлийн өрийн үлдэгдлийн хэмжээгээр ХААН, Хас банк тэргүүлж байгаа бөгөөд тэдгээрийн өрийн үлдэгдэл нийт зээлийн өрийн үлдэгдлийн 88.7 хувьтай тэнцэж байна.

Зоос банкны нийт зээлийн 6.6, Шуудан банкны 2.4, ХААН банк 0.7, Хас банкны 0.7, Хадгаламж банкны 3.2 хувийг хугацаа хэтэрсэн зээл тус тус эзэлж байна.



Иргэдийн хадгаламжийн үлдэгдэл 11.0 тэрбум төгрөг болж байгаа нь өнгөрсөн оноос 4.1 хувиар буюу 471.7 сая төгрөгөөр буурчээ.

Аймгийн 1 хүнд дунджаар 142.9 мянган төгрөгийн хадгаламж ноогдож байна.

**Арилжааны банкуудын нийт зээлийн үлдэгдэлд эзлэх хувь**



**Аж ахуйн нэгж, иргэдэд олгосон зээлийн үлдэгдэл**



**Хүн ам**

2008 оны эцэст 38599 эрэгтэй, 38585 эмэгтэй нийт 77184 хүн ам байнгын буюу 6 сараас дээш хугацаагаар суурин амьдарч байна. 2007 оноос хүн амын тоо 2.9 хувиар буюу 2289 хүнээр буурлаа.

Бөхмөрөн, Өндөрхангай, Сагил, Түргэн, Ховд, Цагаанхайрхан, Улаангом сумдын суурин хүн ам өнгөрсөн оноос 0.1 – 1.7 хувиар өсч, бусад сумдын хүн ам 0.5 – 12.9 хувиар буурсан байна.

Хүйсийн харьцаа 100 хувь, 100 эмэгтэйд 100 эрэгтэй ногдож байна.

Хүн амын 28.9 хувь нь буюу 22.3 мянган нь аймгийн төвд, 18.6 хувь буюу 14.4 мянга нь сумын төвд, 52.5 хувь буюу 40.5 мянга нь хөдөөд амьдарч байна.

Хүн амын насыг 2008 оны 12-р сарын 31-тэй харьцуулж бүтэн насаар бодсоноор 37.7 хувийг / 29.1 мянга/ 0-15 насны хүүхэд, 56.9 хувийг / 43.9 мянга/ хөдөлмөрийн насны хүн ам, 5.4 хувийг / 4.2 мянга/ хөдөлмөрийн нас хэтэрсэн хүмүүс эзэлж 2007 онтой харьцуулахад хүүхдийн эзлэх хувь 0.2 пунктээр буурч, хөдөлмөрийн насны хүн амын эзлэх хувь 0.2 пунктээр өсч, хөдөлмөрийн нас хэтэрсэн хүний эзлэх хувь хэвээр байна.

2008 онд 2324 хүүхэд төрж, 482 хүн нас барж цэвэр өсөлт сүүлийн жилүүдэд хүрээгүй өндөр түвшин 23.5 хувьд хүрсэн ч аймгаас гадагш шилжих хөдөлгөөн зогсолтгүй үргэлжилж улмаар сүүлийн жилд өмнөх 3 жилийн дунджаас 87.3 хувиар нэмэгдсэнээс шалтгаалж хүн амын тоо өнгөрсөн оноос 2.3 мянгаар буурлаа.

19.9 мянган өрх байгаа нь өнгөрсөн оноос 0.1 хувиар буюу 11 өрхөөр өслөө. Нэг өрхөд дунджаар 4 хүн амьдарч байна.

2008 онд 802 гэр бүл гэрлэлтээ бүртгүүлсэн нь өнгөрсөн оноос 17.5 хувиар буурсан байна. 18-аас дээш насны 1000 хүнд 17.2 гэрлэлт ноогдож өнгөрсөн оноос 4.4 пунктээр буурсан байна.

15 гэр бүл гэрлэлтээ цуцлуулсан нь өнгөрсөн оноос 36.4 хувиар өссөн байна. 18-аас дээш насны 1000 хүнд 0.3 цуцлалт ноогдож өнгөрсөн оноос 0.1 пунктээр нэмэгдсэн байна.

54 хүүхэд үрчлэгдсэн нь өнгөрсөн оноос 16.9 хувиар буурсан байна.



**Өрх, өрхийн зарим үзүүлэлт**


Бүтэн өнчин хүүхэд 130, хагас өнчин хүүхэд 2148, өрх толгойлсон хүн 3577 байна. Өнгөрсөн онтой харьцуулахад бүтэн өнчин хүүхдийн тоо 3.0 хувиар, хагас өнчин хүүхдийн тоо 7.5 хувиар тус тус буурч, өрх толгойлсон хүний тоо 6.6 хувиар нэмэгдсэн байна.

8-аас дээш ам бүлтэй 620 өрх, 16 хүртэл насны 4 ба түүнээс дээш хүүхэдтэй 1781 өрх байгаа бөгөөд өнгөрсөн оноос 7.3-25.2 хувиар буурсан байна.


Тайр дутуу 2608 хүн бүртгэгдсэн нь өнгөрсөн оноос 4.7 хувиар өсчээ.




Бүтэн болон хагас өнчин хүүхдийн тоо, жил бүрийн эцсээр




Өрх толгойлсон хүний тоо, оноор



Өрх толгойлсон эмэгтэйдүүд, хүүхдийн тоогоор, 2008 оны эцэст



Олон ам бүлтэй өрхийн тоо, жил бүрийн эцсээр



Тахир дутуу хүний тоо, жил бүрийн эцсээр



### Төрөлт, нас баралт, цэвэр өсөлт


Иргэний бүртгэлийн мэдээгээр 2008 онд 2308 эхээс 2324 хүүхэд төрсөн байна. Өмнөх оноос төрсөн эхчүүд 22.0 хувиар, амьд төрсөн хүүхдийн тоо 21.5 хувиар тус тус өссөн байна.

482 хүн нас барсан нь өнгөрсөн оноос 5 хүнээр буюу 1.4 хувиар буурсан бөгөөд харин цэвэр өсөлт 1842 болж 29.3 хувиар өссөн байна.


Төрөлт, нас баралт, цэвэр өсөлтийг иргэний бүртгэлийн эх сурвалжийг үндэслэн тооцвол мянган хүнд 30 төрөлт, 6 нас баралт ноогдож цэвэр өсөлт 24 байна.

Төрөх үеийн харьцаа 106.8, хүүхэд төрүүлсэн эхчүүдийн 99.9 хувь нь гэр бүлийн баталгаатай байна.


Төрөлт, 2008 оны эцсээр



1000 хүнд ногдох төрөлт, нас баралт, жил бүрийн эцсээр



1000 хүн амд ногдох цэвэр өсөлт, жил бүрийн эцсээр



### Ажилгүйдэл

Аймгийн хөдөлмөр эрхлэлтийн албанд бүртгүүлсэн ажил идэвхитэй хайж байгаа ажилгүй хүний тоо урьдчилсан гүйцэтгэлээр 1404 болж, өнгөрсөн оны мөн үеийнхээс 59.5 хувиар буюу 524 хүнээр өссөн байна. Аймгийн хэмжээнд 832 эмэгтэй ажилгүй гэж бүртгүүлсэн нь нийт бүртгэлтэй ажилгүйдчүүдийн 59.3 хувийг эзэлж байна.

Нийт бүртгэлтэй ажилгүйдчүүдийн 99.0 хувь буюу 1390 хүн урьд өмнө тодорхой ажил хөдөлмөр эрхэлж байсан бол 1.0 хувь буюу 14 хүн нь ямар нэгэн хөдөлмөр эрхэлж байгаагүй, анх удаа ажил хайж бүртгүүлсэн иргэд байна.

Бүртгэлтэй ажилгүйдчүүдийн хөдөлгөөнийг 2008 оны жилийн эцсийн байдлаар авч үзвэл 1447 иргэн шинээр бүртгүүлж, 773 бүртгэлтэй ажилгүйдчүүд ажилд зуучлагдан оржээ.


12-р сард ажилгүйдчүүдэд бүртгүүлэгчдийн 9.4 хувь нь сургууль төгссөн, 90.6 хувь нь бусад шалтгаанаар бүртгүүлсэн, ажилд орогчдын 16.7 хувь нь төрийн төсөвт байгууллагад, 83.3 хувь нь бусад газарт ажилд орсон байна.

Ажилгүйдчүүдийн 58.0 хувь 16-34 насны залуучууд, 16.7 хувь нь дээд, 9.7 хувь нь тусгай дунд болон мэргэжлийн анхан шатны, 70.1 хувь нь бүрэн ба бүрэн бус дунд боловсролтой, 3.5 хувь нь бага болон боловсролгүй хүмүүс эзэлж байна.


16 дээш насны арван мянган хүнд 301 ажилгүйдчүүд ноогдож байгаа нь 2007 оноос 69.0 хувиар өссөн байна.

Улаангом, Давст, Наранбулаг, Түргэн, Ховд, Малчин сумуудад арван мянган хүнд 309-533 ажилгүйдчүүд ноогдож байгаа нь аймгийн дунджаас 8-232 пунктээр дээгүүр байгаа бөгөөд бусад суманд 8-276 пунктээр бага байна.

Ажилгүйдчүүдийн тоо сүүлийн 5 жилээр



XXYX-т шинээр бүртгүүлсэн болон ажилд зуучлагдан орсон хүний тоо, жил бүрийн эцсээр



Бүртгэлтэй ажилгүйдчүүдээс ажилд зуучлагдан орсон иргэдийн бүтэц, байгууллагын төрлөөр




### Эрүүл мэнд

онд 2253 эхээс 2262 хүүхэд амьд төрсөн нь өнгөрсөн оны мөн үеийнхээс төрсөн хүүхдийн тоо 461-ээр буюу 25.7 хувиар илүү байна.

Гэрийн төрөлт 15 гарсан нь өнгөрсөн оноос 6 тохиолдлоор буурсан байна.

Амьд төрсөн хүүхдийн тоо, амьгүй төрсөн хүүхдийн тоо



Хүн амын нас баралт 427 гарсан нь өнгөрсөн оны мөн үеэс 3.6 хувь буюу 16 тохиолдлоор буурч 1000 хүнээс 5 нь нас барж байсан байна.

Тав хүртэлх насны хүүхдийн эндэгдэл 60 гарсан нь 1000 амьд төрөлтөнд 26.5 ноогдож, өнгөрсөн оны




мөн үеэс 12 гаралтаар буюу 16.7 хувиар буурчээ.



5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл Улаангом, Өндөрхангай, Цагаанхайрхан сумдад аймгийн дунджаас бага, Баруунтуруун, Зүүнхангай, Өлгий, Бөхмөрөн сумдад гараагүй бусад сумдад аймгийн дунджаас дээгүүр байна.


Ялангуяа Давст, Зүүнговь, Ховд, Малчин сумдад аймгийн дунджаас 2.5-4.1 дахин өндөр байна.

0-1 насны хүүхдийн эндэгдэл 50 гарч нялхсын эндэгдлийн түвшин 22 байгаа нь өнгөрсөн оны мөн үеэс 13 промилээр буурсан хэдий ч эндэгдлийн үзүүлэлтээр Ховд /80.0/, Зүүнговь /69/, Тариалан /49.4/,Хяргас /42.3/, Завхан /38.5/, Тэс /34.8/, Өмнөговь /29.7/, Малчин /27.0/, Цагаанхайрхан /25.0/ сумдууд аймгийн дунджаас өндөр байна.



Нийт нас баралтын 23.2 хувийг эмнэлгийн нас баралт, үүний 17.2 хувийг хоног болоогүй нас баралт эзэлж байна.

Улаангом суманд 1 эх эндэж, 100.0 мянган амьд төрөлтөнд 44 эхийн эндэгдэл ноогдож өнгөрсөн оны мөн үеэс эхийн эндэгдлийн түвшин 11.5 промилээр буурсан байна. Осол гэмтлийн улмаас 61, хорт хавдрын улмаас 111 хүн нас баржээ.




Осол гэмтлийн улмаас амь насаа алдагсадын 7 тохиолдол буюу 11.4 хувь нь амиа хорлож, 3 тохиолдол буюу 5 % нь бусдад хорлогдож, 6 тохиолдол буюу 9.8 % нь зам тээврийн ослоор, 1 тохиолдол буюу 1.6 % нь үйлдвэрлэлийн, 44 тохиолдол буюу 72.2 хувь нь бусад ослоор тус тус нас барсан байна.




Халдварт өвчнөөр нас барсан 5 тохиолдол бүртгэгдсэний 1 нь мэнэн, 4 нь сүрьеэ өвчний улмаас нас баржээ.

Халдварт өвчнөөр өвчлөгчдийн тоо 907 болж өнгөрсөн оны мөн үеэс 24.1 хувиар буюу 176 гаралтаар нэмэгдсэн байна.


10000 хүн тутмаас 114 нь халдварт өвчнөөр өвчилж байгаа бөгөөд энэ үзүүлэлт Улаангом /219.8/ д аймгийн дунджаас дээгүүр бусад суманд аймгийн дунджаас доогуур байна.



Халдварт өвчнөөр өвчлөгчдийн 30.8 хувь нь гепатит, 32.6 хувь нь БЗХӨ, 5.0 хувь нь сүрьеэгээр, 3.2 хувь нь мөөгөнцрөөр, 0.2 хувь нь гахайн хавдраар, 28.2 хувь нь бусад халдварт өвчнөөр өвчилжээ.



Өнгөрсөн оны мөн үеэс гепатит 70, хамуу 84, мөөгөнцөр 19, тэмбүү 24, трихомониаз 55, салхинцэцэг 1 гаралтаар нэмэгдэж, хүйтэн 45, гахайн хавдар 53, улаанууд 35, гаралтаар тус тус буурчээ. Өмнөх оны мөн үед гарч байгаагүй мэнэн 1, суулгалт халдвар 3, гар хөл амны өвчний 29 тохиолдол гарсан байна.



Амбулаториор 378.6 мянган хүнд үзлэг хийгдэж, стационариар 20.6 мянган хүн эмчлэгдсэн байна.

Хувийн хэвшлийн 8 эмнэлэг 16.1 мянган хүнд үзлэг эмчилгээ, оношлогоо хийж 38.4 сая төгрөгийн орлоготой ажилласныг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулбал үйлчлүүлэгчид 2.9 мянгаар, орлого нь 9.3 сая төгрөгөөр нэмэгджээ.

**Нийгмийн даатгал, халамж, нөхөн олговор**

НДС- д шимтгэлээр 4267.8 сая төгрөг оруулахаас 4411.3 сая төгрөг оруулж төлөвлөгөөг 103.4 хувиар биелүүлж, 143.5 сая төгрөгөөр давууллаа. НДС-ийн тэтгэвэр тэтгэмжинд 8980.6 сая төгрөг зарцуулсан нь өнгөрсөн оноос 38.5 хувиар өссөн байна. Сангуудаар авч үзвэл 2007 оноос тэтгэвэрийн даатгалын сангийн орлого 28.7 хувиар, ЭМД-н сангийн орлого 39.8 хувиар, ҮОМШӨ-н сангийн орлого 23.6 хувиар, ажилгүйдлийн даатгалын сангийн орлого 77.3 хувиар өсч харин тэтгэмжийн даатгалын сангийн орлого 10.8 хувиар буурчээ.

НДС-ийн шимтгэлийн төлөвлөгөөг Баруунтуруун, Давст, Зүүнговь, Ховд, Улаангом сумууд 101.1 - 114.4 хувиар



биелүүлсэн бөгөөд бусад сумууд 1.8 - 7.2 хувиар тасалсан байна.

8.7 тэрбум төгрөг тэтгэвэрт, 1.2 тэрбум төгрөг ЭМД-ын санхүүжилтэнд зориулан зарцуулж тэтгэвэр, тэтгэмж, эрүүл мэндийн санхүүжилтийг бүрэн олголоо. НДС 176.8 сая төгрөгийн авлагатай гарсан нь бүгд иргэд, аж ахуй нэгжид ноогдож байна.


Нийгмийн даатгалд 2008 онд 22333 хүн хамрагдсан нь 2007 оныхоос 6567 хүнээр буюу 41.6 хувиар өссөн байна.

Нийгмийн халамжийн сангаас давхардсан тоогоор 98.6 мянган хүнд 7 тэрбум 348.2 сая төгрөгийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж, хөнгөлтүүд олгогдсон нь өнгөрсөн оноос хүний тоо 1.9 хувь буюу 1.9 мянгаар өсч, зарцуулсан хөрөнгийн хэмжээ 4.6 хувиар буюу 354.9 сая төгрөгөөр буурчээ.


Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжийн бүтцийг авч үзвэл 11.4 хувь нь халамжийн тэтгэвэрт, 2.6 хувь нь нөхцөлт мөнгөн тэтгэмжид, 41.9 хувь нь улсын төсвөөс олгосон тэтгэмжид, 37.2 хувь нь хүүхдийн тэтгэмжид (улиралд олгодог 25.0 мян.төг), 5.3 хувь нь ахмад настан, ХБИ-дэд олгосон хөнгөлөлт тус тус зарцуулагдсан байна.

4 хүнд 13.6 сая төгрөгийн нөхөн олговор олгосон нь өнгөрсөн оныхоос 42.6 хувиар буюу 10.2 сая төгрөгөөр буурсан байна.

Нийгмийн даатгалын сангуудын зарлагын бүтэц, 2008




Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжийн зарцуулалтын бүтэц, 2008




Боловсрол


2008-2009 оны хичээлийн жилд ерөнхий боловсролын 2 цогцолбор, 10 ахлах, 9 дунд, 6 бага сургуулийн өдрийн ангид 20.4 мянган хүүхэд суралцаж, өнгөрсөн оны мөн үеэс суралцагчдын тоо 0.1 мянгаар бага байна.



Бага, суурь, бүрэнд дунд боловсрол эзэмшигчдийг сүүлийн 3 хичээлийн жилээр харуулбал:



Энэ хичээлийн жилд ерөнхий боловсролын сургуулийн 1-р ангид 3035 хүүхэд элсэж орсон нь өмнөх хичээлийн жилээс 750 хүүхдээр нэмэгдсэн байна.



ЕБС-д өдрөөр суралцагчид, багшлах боловсон хүчний тоо, сургуулийн хэв шинжээр

Сургуулийн хэв шинж	бүгд	эмэгтэй	багшийн тоо
цогцолбор	7725	4006	348
ахлах	7882	4083	384
дунд	4330	2152	205
бага	492	239	27
ДУН	20429	10480	964
ӨОМҮГ	20547	10563	895


Дээд сургууль, коллежид 1890 оюутан суралцаж байгаа нь өмнөх хичээлийн жилийнхээс 437 хүнээр нэмэгдсэн байна.

Суралцагчдын тоо, хичээлийн жилүүдээр

	2004-2005	2005-2006	2006-2007	2007-2008	2008-2009
Улаангом коллеж	968	961	1002	1131	1700
ХДС салбар	176	175	167	175	190

ЕБС-д 964 багш ажиллаж өмнөх хичээлийн жилийнхээс 69-өөр нэмэгдсэн байна. Нэг багшид дунджаар 21 хүүхэд ноогдож байгаа нь өмнөх хичээлийн жилийнхээс 2 хүүхдээр буурсан байна.

нэг багшид ноогдох хүүхдийн тоо




Хүүхдийн 1974 ортой 30 дотуур байранд 3396 хүүхэд амьдарч байгаа бөгөөд үүний 94.5 хувь нь малчдын хүүхэд байна. Нийт дотуур байрны 27 нь стандартын, 3 нь стандартын бус байр байгаа бөгөөд өнгөрсөн оноос байрны тоо нэмэгдээгүй байна.

6-14 насны хүүхдүүдээс сургуулийн насны 573 хүүхэд сургуулийн гадна байгаагийн 46.2 хувь буюу 265 нь сургуульд огт ороогүй, 308 нь сургуульд ороод завсардсан хүүхдүүд байна. Сургуулийн гадна байгаа нийт хүүхдийн 40.1 хувь нь эмэгтэй, 27.2 хувь нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд байгаа ба 39.1 хувь нь амьдралын гачигдлийн улмаас, 23.7 өөрөө сурах хүсэлгүй, 11.9 хувь нь ажил эрхлэхээр, 31.6 хувь нь өвчний улмаас, 8.2 хувь нь бусад шалтгаанаар сургуульд суралцахгүй байна. Сургуульд ороод засвардсан хүүхдийн 82.1 хувь буюу 253 нь 1-5-р ангиас завсардсан хүүхдүүд байна.

Энэ хичээлийн жилд сургуулийн өмнөх 142 бүлэгт 4.7 мянган хүүхэд хамрагдсаны 2.4 мянга нь эмэгтэй хүүхэд байна.

СӨБ-д хамрагдах хүүхдийн тоо



2007-2008 оны хичээлийн жилд ЕБС-ийн бага боловсролыг 1997, суурь боловсролыг 1828, бүрэн дунд боловсролыг 1475 хүүхэд өдөр болон эчнээгээр эзэмшжээ.


ХДС-ийг хөдөлмөрийн эдийн засагч, ня-бо бүртгэл мэргэжлээр 72 оюутан төгсч, Улаангом коллежийн дээд боловсролыг 31 хүүхэд, анхан шатны боловсролыг 373 хүүхэд тус тус эзэмшжээ.

Суурь болон бүрэн дунд, мэргэжлийн анхан шатны, дээд боловсролыг 3779 хүүхэд эзэмшиж төгссөн нь өнгөрсөн оны мөн үеэс 2.9 хувиар илүү байна.



**Соёл**


Аймгийн соёл урлагийн төв нийт 20.5 мянган хүнд 136 тоглолтоор үйлчилж 18.1 сая төгрөгийн орлоготой ажилласан нь өнгөрсөн оноос тоглолтын тоо 4.6, орлого нь 33.8 хувиар өссөн байна.




Орон нутгийг судлах музей 3.9 мянган хүнд үйлчилж 1.0 сая төгрөгийн орлоготой ажилласан ба нийт үзэгчдийн 57.4 хувь нь хүүхэд байна.

Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад үзэгчдийн тоо 34.5 % , орлого нь 9.9 хувиар өсчээ.

Энэ онд 5.8 сая төгрөгийн 38 үзмэр шинээр нэмсэн байна



Төв номын сан 3.5 мянган байнгын уншигч, 26.3 мянган ирэгсдэд 34.2 мянган номоор үйлчилж 646.5 мянган төгрөгийн орлоготой ажилласан ба өнгөрсөн оны мөн үеэс уншуулсан ном 0.6 хувиар буурч, орлого нь 18.8 хувиар өсчээ.



**Хөдөө аж ахуй  
Малын тоо**

Аймгийн хэмжээнд мал тооллогын дүнгээр 9.9 мянган малчин өрхийн 20.6 мянган малчид мал аж ахуйн үйлдвэрлэл эрхэлж байна. Малчин өрхийн тоо өнгөрсөн оноос 197-оор, малчид 1.3 мянган хүнээр буурсан байна. 1 малчинд дунджаар 121.1 толгой мал ногдож байна.

2008 оны эцэст 2499.3 мянган толгой мал үүний дотор 16.0 мянган тэмээ, 79.3 мянган адуу, 118.2 мянган үхэр, 1215.0 мянган хонь, 1070.9 мянган ямаатай болж тэмээ 0.5 мянга, адуу 5.5 мянга, үхэр 12.1 мянга, хонь 63.2 мянга, ямаа 72.9 мянган толгойгоор тус тус буурч, өнгөрсөн оноос нийт малын тоо 5.8 хувиар буюу 154.2 мянган толгойгоор буурсан байна. /Зураг1,2/

Энэ жил том малын хорогдол /223.7 мянга/, төл малын хорогдол нилээд /210.9 мянга/ гарсан, зах зээлд ойртох, байгаль цаг уур, бэлчээрийн хомсдолоос шалтгаалж өөр аймаг хотод 618 малтай өрхийн 146.6 мянган толгой мал шилжиж суурьшсан, мөн малчдын гол орлого болох малын түүхий эдийн үнэ ханш буурч мал нь өрхийн хэрэглээний зарлагыг нөхөх, банкны өр зээл төлөх төлбөрийн хэрэглээний үүрэг гүйцэтгэх болсон зэргээс шалтгаалж малын тоо толгой буурлаа.



Малын тоо өнгөрсөн оноос Зүүнговь, Давст, Наранбулаг, Өлгий, Өмнөговь, Өндөрхангай, Тариалан, Тэс, Хяргас, Улаангом, Цагаанхайрхан, Малчин сумдад 2.3-20.5 хувиар буурсан байна.

7 сум өнгөрсөн оныхоос бүх малаа өсгөсөн ба, үүнээс Баруунтуруун, Бөхмөрөн, Зүүнхангай, Ховд сумууд малаа таван төрөлдөө өсгөжээ.

Нийт сүрэгт хонь 48.6, ямаа 42.8, үхэр 4.7, адуу 3.2, тэмээ 0.6 хувийг тус тус эзэлж, үхрийн эзлэх хувь 0.2 пунктээр, ямааны эзлэх хувь 0.3 пунктээр тус тус буурч, хонины эзлэх хувь 0.4 пунктээр өсчээ. /зураг4/ Сумдыг малын тоогоор нь бүлэглэвэл:

- 200.0 мянгаас дээш толгой малтай сум - 1 сум  
Тэс / 272.1 мянган толгой /
- 150.0 – 200.0 мянган толгой малтай сумдын тоо – 7 сум  
Зүүнхангай /155.8/, Сагил / 156.6 /, Хяргас / 156.4 /, Өмнөговь / 164.5 /, Наранбулаг / 162.2 /, Өндөрхангай / 179.2 /, Улаангом / 185.4 /
- 100.0 -150.0 мянган толгой малтай сумдын тоо- 7 сум  
Бөхмөрөн /101.4/, Түргэн / 107.9 /, Малчин /110.0/, Ховд / 115.0 /, Цагаанхайрхан /117.7/, Тариалан /118.5/, Зүүнговь / 126.2 /
- 50.0- 100.0 хүртэл малтай сумдын тоо – 4 сум  
Баруунтуруун / 55.4 /, Давст / 67.1/, Завхан / 85.8/, Өлгий / 96.3 /


Нийт малын 9.5 хувийг эзэлж буй Тэс сум 237.8 мянган толгой малтайгаар хамгийн олон малтай, 2.2 хувийг эзэлдэг Баруунтуруун сум 55.4 мянган толгой малтай болж хамгийн цөөн малтайд орж байна.

Нийт малын тоогоор эвний 5 д орж сумууд:	Мянган толгой Үүнээс	
	тэмээгээр	адугаар
Тэс-237.8	Завхан- 5053	Өндөрхангай-8089
Улаангом-185.4	Наранбулаг- 2121	Тэс- 8021
Өндөрхангай-179.1	Тэс - 1762	Зүүнхангай- 6846
Өмнөговь-104.5	Өлгий - 1147	Улаангом - 5494
Наранбулаг-102.2	Өмнөговь- 987	Зүүнговь- 5461
Дунд зэлэх хувь- 32.4	Дунд зэлэх хувь- 69.8	Дунд зэлэх хувь- 42.8
Өсгөсөн сум- 7	Өсгөсөн сум- 8	Өсгөсөн сум- 4
Өсөлт, буурлт, хувь-94.2	Өсөлт, буурлт, хувь-97.0	Өсөлт, буурлт, хувь-93.5

Мянган толгой		
үхэрээр	хоньор	ямаагаар
Тэс- 21.3	Тэс - 143.8	Улаангом - 75.9
Улаангом- 16.5	Улаангом- 87.1	Өндөрхангай - 75.4
Өндөрхангай- 8.9	Өндөрхангай- 86.3	Наранбулаг - 74.3
Зүүнговь- 8.5	Хяргас - 84.8	Өмнөговь - 73.6
Зүүнхангай- 7.1	Зүүнхангай - 84.4	Ховд - 72.1
Сагил- 6.5	Өмнөговь - 80.1	Сагил - 71.2
Дунд зэлэх хувь- 58.2	Дунд зэлэх хувь- 46.6	Дунд зэлэх хувь- 41.3
Өсгөсөн сум- 6	Өсгөсөн сум- 8	Өсгөсөн сум- 6
Өсөлт, буурлт, хувь-90.7	Өсөлт, буурлт, хувь-95.1	Өсөлт, буурлт, хувь-93.6


Аймгийн 1 хүнд дунджаар 32 толгой мал ноогдож сумдаар авч үзвэл Сагил суманд 67, Хяргас суманд 62, Зүүнхангай суманд 60, Түргэн суманд 55, Наранбулаг, Өмнөговь, Бөхмөрөн, Өлгий, Завхан, Ховд, Тэс, Давст, Малчин, Өндөрхангай, Цагаанхайрхан, Зүүнговь сумуудад 35-49 ноогдож байгаа нь аймгийн дунджаас 3-17 толгойгоо малаар илүү, Улаангом сумын нэг хүнд дунджаар 8, Баруунтуруун суманд 20 Тариалан суманд 30 толгой мал ноогдож байгаа нь аймгийн дунджаас 2 - 24 толгой малаар доогуур байна.

Малын тоо, мянган толгой, /зураг1/








/зураг2/




/зураг3/



Зураг 4



Зураг 5



Сумдыг бүсчлэн тооцож үзвэл баруун бүсэд нийт малын 29.7 хувь буюу 742.3 мянган мал, зүүн бүсэд 25.5 хувь буюу 630.5 мянган мал, өмнөд бүсэд 20.3 хувь буюу 508.2 мянган мал, хойт бүсэд 17.3 хувь буюу 433.0 мянган мал, төвийн бүсэд 7.4 хувь буюу 185.4 мянган мал тус тус ноогдож байна.

Нийт мал сүргийн 99.3 / 2482.6 мянган / хувь нь амины аж ахуйд, 0.7 хувь нь / 16.7 мянган / албан газарт ноогдож, албан газрын мал өнгөрсөн оноос 1.1 мянгаар буурсан байна.

Мөн бодод шилжүүлснээр 557.8 мянган малтай болж өнгөрсөн оноос 30.0 мянган толгойгоор буурсан байна.



2008 онд 146.6 мянган мал бүхий 618 өрх гадагш шилжиж үүнд Тариалан сумаас 27.3 мянган мал, 143 өрх, Тэс сумаас 28.8 мянган мал, 66 өрх, Улаангом сумаас 56 өрх, 8.9 мянган мал, Малчин сумаас 67 өрх, 15.9 мянган мал, Наранбулаг сумаас 62 өрх, 15.7 мянган мал шилжсэн байна. Аймгийн хэмжээгээр өмнөх 2 жилийн дунджаас гадагш шилжсэн малтай өрхийн малын тоо 4.4 дахин өссөн байна.

Мал, өрх олноор шилжиж буй үндсэн шалтгаан нь бэлчээрийн хүрэлцээгүй байдал, байгаль цаг уурын өөрчлөлтөөс шалтгаалж өвс ургамал ургахгүй цөлжиж



байгаа байдал хамгийн голлох нөлөөтэй гэсэн судалгааны дүгнэлт гарсан байна.

ХЭЭЛТЭГЧ МАЛ


1136.1 мянган хээлтэгч мал тоологдож хээлтэгчийн тоо өнгөрсөн оноос 8.3 мянгаар буурсан байна.

Нийт сүргийн 45.5 хувь нь хээлтэгч мал байгаа бөгөөд үүнээс тэмээний 30.9, адууны 28.7, үхрийн 42.9, хонины 46.9, ямааны 45.5 хувь нь хээлтэгч мал эзэлж байна.


АМИНЫ МАЛЫН БҮЛЭГЛЭЛТ

100 хүртэлх малтай өрх хувийн малтай өрхийн 41.2 хувийг эзэлж байгаа нь өнгөрсөн оноос 1.6 пунктээр, 101-200 толгой малтай өрх 26.6 хувийг эзэлж өнгөрсөн оноос 0.1 пунктээр өсч, 201-500 толгой малтай өрх 1.2, 501-999 малтай өрх 0.5 пунктээр тус тус буурчээ. 1000 –аас дээш малтай 200 өрх байгаа нь 2007 оноос 9 өрхөөр буурсан байна.

/зураг 7/



/зураг 8/




Тэс, Бөхмөрөн, Давст, Өндөрхангай, Зүүнговь, Зүүнхангай, Түргэн, Хяргас, Сагил сумдын 200 хүртэл малтай өрхийн эзлэх хувийн жин аймгийн дунджаас 1.4- 22.3 пунктээр бага байна.


Төллөлт, төл бойжилт

Оны эхний эхийн 77.6 хувь буюу 888.5 мянган эх мал төллөж, гарсан төлийн 76.5 хувь буюу 680.0 мянган төл бойжиж байна. Өнгөрсөн онтой харьцуулахад төллөлт 9.5, бойжилт 17.5 пунктээр доогуур, харин төлийн хорогдол 3.6 дахин өссөн байна. Завхан, Малчин, Наранбулаг, Өлгий, Давст, Баруунтуруун, Цагаанхайрхан, Зүүнговь, Улаангом сумуудын төллөх насны эхийн 56.4-74.3 хувь нь төллөсөн нь аймгийн дунджаас 3.3-21.2 пунктээр бага байна.

Зураг 1




Зураг 2





100 эх малаас 59 төл үүний дотор 37 ботго, 43 унага, 55 тугал, 67 хурга, 52 ишиг бойжуулсан нь өнгөрсөн оноос ботго 3, унага 14, тугал 16, хурга 19, ишиг 28 төлөөр бага бойжуулсан байна. /зураг6/

Зураг 3




**Том малын зүй бусын хорогдол**

Оны эхний малын 8.4 хувь буюу 223.7 мянган толгой мал хорогдсон нь өнгөрсөн оноос 4.7 дахин буюу 176.0 мянган толгойгоор илүү байна. 2007 онтой харьцуулахад тэмээний хорогдол 2.1, адууных 2.5, үхрийн хорогдол 4.1, хонь ба ямааны хорогдол тус бүр 4.8 дахин нэмэгдсэн байна. /Зураг1/




Зураг 2



Нийт хорогдлын 7.4 хувийг өвчний хорогдол эзэлж байна.

Нийт хорогдлын 47.1 хувийг хонь, 44.0 хувийг ямаа, 6.5 хувийг үхэр, 2.3 хувийг адуу, 0.2 хувийг тэмээний хорогдол эзэлж байна. /Зураг 3/



Бөхмөрөн, Түргэн, Хяргас, Ховд, Завхан, Сагил, Малчин, Зүүнговь сумдын оны эхний малын 0.4 – 6.4 хувь нь хорогдож аймгийн дунджаас 2.0-8.0 пунктээр бага, бусад сумдын оны эхний малын 8.7-24.5 хувь нь хорогдсон нь аймгийн дунджаас 0.4-16.1 пунктээр их байна.

**ТЭЖЭЭВЭР АМЬТАД**

2008 онд 110 гахай, 147 шувуу, 71 бүл зөгий, 1 илжиг тоологдсон ба 2007 оныхоос бүл зөгий 11, гахай 37-оор өсч, шувуу 51, илжиг 1-ээр буурчээ.

**ЦЭВЭР ЭРЛИЙЗ МАЛ**

2008 онд цэвэр үүлдрийн хонь 454.7 мянга, сайжруулсан үүлдрийн хонь 130.8 мянга, нутгийн шилдэг омгийн ямаа 150.2 мянга, сайжруулсан нутгийн үүлдрийн ямаа 76.8 мянга, нутгийн шилдэг омгийн адуу 14.7 мянга тоологдсон нь сайжруулсан нутгийн үүлдрийн хонь 9.0 мянга, нутгийн шилдэг омгийн ямаа 30.3 мянга, шилдэг омгийн адуу 0.7 мянгаар буурч, харин нутгийн цэвэр үүлдрийн хонь 19.5 мянга, сайжруулсан нутгийн үүлдрийн ямаа 73.9 мянгаар тус тус өсчээ.

**МАЛЧДЫН НИЙГЭМ АХУЙН ҮЗҮҮЛЭЛТ**

Нийт 9.9 мянган малчин өрхийн 7.6 мянга нь буюу 76.9 хувь цахилгааны эх үүсвэртэй үүний 96.9 хувь нь нарны зайн эх үүсвэрээр хангагдсан байгаа нь өнгөрсөн оноос 1.5 хувиар өссөн байна. 5.9 мян өрх телевизорттой, 6.4 мянган өрх малын хашаатай, 0.8 мянган өрх худагтай, 1.6 мянган өрх авто

машинтай 3.4 мянган өрх мотоциклтой, 0.1 мянган өрх трактортой байна.

Өнгөрсөн оноос худагтай өрхийн тоо 229-өөр буурч, авто машинтай өрхийн тоо 44, хашаатай өрхийн тоо 22, телевизортэй өрхийн тоо 686, мотоциклтой өрхийн тоо 956-аар тус тус өсчээ.

**2008 онд шинээр гаргасан ба засварласан худаг, малжуулалт**

Энэ онд шинээр 37 худаг гаргаж, 24 худаг засварласан ба түүнд нийт 468.4 сая төгрөг зарцуулсан байна.

2008 онд аймгийн хэмжээнд 109 өрх малжуулах арга хэмжээнд хамрагдаж тэдэнд 1.0 мянган толгой мал олгож, 42.3 сая төгрөг зарцуулжээ. Нийт олгосон малын 99.3 хувь нь бөг мал, 0.7 хувь нь бод мал байна.


**ТАРИАЛАЛТ**

2.2 мянган га-д үр тариа, үүнээс 2.0 мянган га-д улаанбуудай, 225.3 га-д төмс, 167.9 га-д хүнсний ногоо, 358.9 га-д тэжээлийн ургамал нийт 3.0 мянган га-д тариалалт хийлээ.

Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад үр тариа 658.5 га, төмс 42.6 га, хүнсний ногоо 41.4 га-аар тус тус өсч, тэжээлийн ургамал 1159.8 га-аар буурчээ.

Баруунтуруун сум 1246 га, Тариалан 404 га, Сагил сум 239.5 га, Улаангом 121 га-д үр тариа тариалсан нь аймгийн нийт тариалсан үр тарианы 90.6 хувийг эзэлж байгаа бөгөөд өнгөрсөн оны мөн үеэс 610 га-аар өссөн байна.

Улаангом, Баруунтуруун, Тариалан сумдууд 310.5 га д төмс, хүнсний ногоо тариалсан нь нийт тариалалтын 79.0 хувь болж өнгөрсөн оноос 70.4 га-аар өссөн байна.



**УРГАЦ ХУРААЛТ**


2008 онд 3149.7 тн үр тариа, 2321.0 тн төмс, 1826.1 тн хүнсний ногоо хураан авсныг 2007 онтой харьцуулбал хураан авсан үр тариа 1001 тн, төмс 360.6 тн, хүнсний ногоо 334.0 тн-оор тус тус илүү байна.

Хураан авсан үр тарианы 33.2, төмсний 86.3, хүнсний ногооны 88.8 хувийг иргэдийн хураан авсан ургац эзэлж байна.


Үр тарианы 94.3 хувь нь Баруунтуруун, Тариалан, Сагил, Улаангом сумдад, хураан авсан төмсний 83.5 хувь нь Улаангом, Баруунтуруун, Тариалан сумдад, хүнсний ногооны 81.3 хувь нь Улаангом, Баруунтуруун сумдад ноогдож байна.

1га-аас 14.2 цн үр тариа, 103.0 цн төмс, 108.9 цн хүнсний ногоо хураан авлаа. Өнгөрсөн 2007 онтой харьцуулахад үр тарианы га-ийн ургац 0.4 цн-ээр нэмэгдэж, төмсний га-ийн ургац 4.3 цн-ээр, хүнсний ногооных 9.5 цн-ээр багассан байна.

50.8 мянган тн байгалийн хадлан, гар тэжээл 2.9 мянган тн-ыг бэлтгэсэн нь өнгөрсөн оныхоос хадлан 311 тн, гар тэжээл 341.7 тн-оор тус тус буурсан байна. Зураг1



Зураг 2






**ХАА-н зарим бүтээгдэхүүний зах зээлийн дундаж үнэ**

12-р сарын 21-25 ны хооронд ХАА-н бүтээгдэхүүний үнийг судлан өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад ХАА-н гол бүтээгдэхүүн мал, мах болон түүхий эдийн үнэ ерөнхийдөө буурах хандлагатай байлаа.

Өнгөрсөн сараас морь, гүү, үнээ, ишиг, адуу ба үхрийн шир, хонины арьс, түлээний мод, улаан лооль, сонгино, хонины махны үнэ 100-20000 төгрөгөөр тус тус буурч, харин эр үхэр, эм ямаа, хурга, ямааны арьс, дотор мах, хонины арьс, чацаргана, үхрийн нүд, тэмээ ба ямааны махны үнэ 100-10000 төгрөгөөр өсчээ.

Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад бүх төрлийн малын үнэ 3.0-100.0 мянгаар төгрөгөөр, мах болон ХАА-н бусад бүтээгдэхүүний үнэ 200-23000 төгрөгөөр буурсан байна.

Чацаргана ба үхрийн нүдний үнэ 500 төгрөгөөр, түлээний модны үнэ 12500 төгрөгөөр өссөн байна.



**Жимс, жимсгэнэ тариалалт, хураалт**

132.2 га-д жимс, жимсгэнэ тариалж түүнд 179.8 мянган бут мод суулгажээ.


Энэ жил 126.1 мянган ширхэг үр жимсээ өгөх бут, модноос 216.1 тн чацаргана, үхрийн нүд хураан авчээ.

Өнгөрсөн онтой харьцуулбал хураан авсан чацаргана 114.3 тн-оор, үхрийн нүд 22.7 тн-оор нэмэгдсэн байна. Хураан авсан жимсээ зах зээлд бүрэн борлуулж түүнээсээ 280.9 сая төгрөгийн орлого олсон байна. Нэг бутнаас дунджаар 1.7 кг жимс хураан авчээ. Нийт тариалсан талбайн 80.0 хувь, хураан авсан жимсний 82.4 хувийг аж ахуйн нэгж, байгууллагад ногдож байна.

**АЖ ҮЙЛДВЭР**

Аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүний үйлдвэрлэл 2005 оны зэрэгцүүлэх үнээр 4.3 тэрбум төгрөг болж өнгөрсөн оны мөн үеийнхээс 4.0 хувиар буюу 166.2 сая төгрөгөөр өссөн байна.

**Аж үйлдвэрийн бүтээгдэхүүний өсөлт бууралт /сая төг/**




Өнгөрсөн оны мөн үеэс /зэрэгцүүлэх үнээр тооцсоноор/ мод модон бүтээгдэхүүний үйлдвэрлэл 70.9 бусад боловсруулах үйлдвэрлэл 61.4 д, нүүрс олборлолт 25.4, усан хангамж 12.7, хүнс ундааны үйлдвэрлэл 7.5 хувиар өсч, эрчим хүч түгээлт 4.8, хувцас үйлдвэрлэл 12.7, нүүрснээс бусад ашигт малтмал олборлолт 42.5 хувиар тус тус буурсан байна.

Оны үнээр 6.5 тэрбум төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж 6.7 тэрбум төгрөгийн борлуулалтын орлоготой ажилласан байна.

Нийт үйлдвэрлэлтийн 57.7 хувийг хүнс ундааны үйлдвэрлэл, 14.9 хувийг эрчим хүч түгээлт, 6.7 хувийг нүүрс олборлолт, 10.8 хувийг бусад ашигт малтмал олборлолт, 7.6 хувийг бусад боловсруулах үйлдвэрлэл, 1.1 хувийг усан хангамж, 0.9 хувийг мод модон бүтээгдэхүүний үйлдвэрлэл, 0.3 хувийг хувцас үйлдвэрлэл эзэлж байна. Зураг 2

**Аж үйлдвэрийн салбарын бүтэц /хувиар/**



Салбарын бүтэц өнгөрсөн оноос хүнс ундааны үйлдвэрлэлт 7.0, бусад аж үйлдвэрийн үйлдвэрлэл 2.4, нүүрс олборлолт 1.3, мод модон бүтээгдэхүүний үйлдвэрлэл 0.3 пунктээр өсч, алт олборлолт 7.1, эрчим хүч түгээлт 3.9 пунктээр буурч хувцас



Үйлдвэрлэл, усан хангамжийн эзлэх хувийн жин өнгөрсөн оны түвшинд байна.


Салбарын бүтэц

	2004	2005	2006	2007	2008
Цахилгаан дулаан түгээлт	29.1	27.6	21.7	18.8	14.9
Нүүрс олборлолт	9.4	10	6.7	5.4	6.7
Бусад ашигт малтмал олборлолт	39.3	23.5	26.9	17.9	10.8
Хүнс ундаа					
үйлдвэрлэлт	14.9	26	34.1	50.7	57.7
Хувцас үйлдвэрлэлт	0.2	0.5	0.3	0.3	0.3
Мод модон бүт					
үйлдвэрлэлт	0.8	0.7	0.2	0.6	0.9
бусад боловсруулах					
аж үйлдвэр	3.6	9.3	8.4	5.2	7.6
Усан хангамж	2.7	2.4	1.7	1.1	1.1
Дүн	100.0	100.0	100.0	100.0	100.0

Өнгөрсөн оны мөн үед аж үйлдвэрийн салбарт 452 ажиллагсад ажиллаж байсан бол энэ онд 618 ажиллагсад ажиллаж ажиллагсадын тоо 36.7 хувиар өссөн боловч хөдөлмөрийн бүтээмж 23.9 хувиар буурсан байна.

2005 оны зэрэгцүүлэх үнээр тооцсоноор 2004 оноос боловсруулах үйлдвэрлэл 2.8 д өсч, эрчим хүч усан хангамжийн үйлдвэрлэл 3.6 хувиар өсч, уул уурхай олборлолтын салбар 43.7 хувиар буурсан байна. /зураг-3/


аж үйлдвэрийн бүтээгдэхүүний өсөлт бууралт/2004=100%/



Аж үйлдвэрийн салбарын зарим нэрийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлтийг 2004 оны мөн үетэй харьцуулбал талх 3.8 д, өлөн 4.4 д, нарийн боов 88.5, архи 65.8, ундаа 17.4, цэвэр ус түгээлт 36.4, дулаан 17.5 нүүрс олборлолт 28.3, хувиар өсч, алт олборлолт 67.0,


цахилгаан үйлдвэрлэлт 85.2 хувиар тус тус буурсан байна. /Зураг – 4.5,6/ Зураг-4

Гол нэрийн бүтээгдэхүүний өсөлт бууралт хувиар 2004=100%/




Зураг-5

гол нэрийн бүтээгдэхүүний өсөлт бууралт хувиар 2004=100%



Зураг-6

гол нэрийн бүтээгдэхүүний өсөлт бууралт /2004=100%/



Төвийн нэгдсэн сүлжээнд холбогдсонтой холбоотойгоор сумдын дизель станцууд ажиллахаа больсноос шалтгаалж цахилгаан үйлдвэрлэлтийн хэмжээ 2004 оноос 85.2 хувиар буурч



байгаа боловч импортын цахилгаан 71.4 хувиар, цахилгааны хэрэглээ 65.2 хувиар өссөн байна. /Зураг - 7/


Цахилгааны хэрэглээ



Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад аж үйлдвэрийн чиглэлийн аж ахуйн нэгжүүд 45 нэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж 16 нэрийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлтэнд өсөлт гарч 24 нэрийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл буурсан байна. Гол нэрийн бүтээгдэхүүнээс чацарганы тос 5.5 д, зүсмэл 2.4 д, тоосго 2.1д, гурил 2.6 д, хөх шир 2.2 д, хиам 64.5, витавит жүүс 58.1, дээврийн хавтан 56.3, нүүрс олборлолт 25.2, сироп 24.7, вакум цонх 21.9 замын хавтан 20.7, гэрийн хөшиг 13.0, цэвэр ус түгээлт 12.7, өлөн 8.6, хувиар өсч, модон эдлэл 88.0, зайрмаг 67.6, тараг 66.3, цахилгаан түгээлт 59.5, гэрийн хөшиг 56.5, талх 50.0, шохой 50.0, алт олборлолт 42.5, эсгий 37.8, булигар 36.8, гэрийн цагаан бүрээс 32.1, шевро 30.8, архи 29.4, дээл 28.0, гутал 27.5, ундаа 25.6, иоджуулсан давс 22.3, гурил 21.1, нарийн боов 20.9, хэрчсэн гурил 2.1, дулаан түгээлт 1.9, хувиар тус тус буурсан байна.


Зураг-4

Гол нэрийн бүтээгдэхүүний өсөлт бууралт хувиар 2004=100%/




Зураг-5

гол нэрийн бүтээгдэхүүний өсөлт бууралт хувиар 2004=100%




Зураг-6

гол нэрийн бүтээгдэхүүний өсөлт бууралт /2004=100%/



Өнгөрсөн оны мөн үеэс		АУ-ийн салбарын мэдээнд хамрагдсан ААН	Шинэ нэр төрлийн бүтээгдэхүүн
өссөн нэр төрөл	буурсан нэр төрөл		
20	24	40	5
нүүрс ус түгээлт	цахилгаан дулаан	үхрийн мах	түлхүүрийн оосор
гурил	алт	үхрийн мах	өмдний тэлээ
хиам	ид/сан давс	варень	ингэний хоормог
чац/ны тос	архи		
хивэг	ундаа		
хөх шир	хэрчсэн гурил		
вакум цонх	гутал		
замын хавтан	эм хослол		
тоосго	пальто		
сироп	дээл		
жүүс	булигар		
өлөн	шевро		
гэрийн хөшиг	эсгий		
зүсмэл	зайрмаг		
дээврийн хавтан	талх		
	тараг		
	гэрийн бүрээс		
	шохой		
	цэвэр ус		
	модон эдлэл		
	хөнжил		
	нарийн боов		
	ботинк		


Зураг-7



**Барилга**


Барилгын гүйцэтгэгч 32 аж ахуйн нэгжүүд 12.1 тэрбум төгрөгийн БУИЗ-ын ажил гүйцэтгэсэн нь өнгөрсөн оны мөн үеэс /инфляциар засварласанаар/ 22.3 хувиар буурсан байна. Нийт гүйцэтгэсэн ажлын 89.4 хувийг шинэ барилга, 10.5 хувийг их засварын ажил эзэлж байна.

Барилга угсралт, их засварын ажлын хувийн жин




Нийт барилга угсралт их засварын ажлын 58.8 хувь нь буюу 7.1 тэрбум төгрөгийн ажлыг барилга объектод, 41.1 хувь нь буюу 5.0 тэрбум төгрөгийн ажлыг инженерийн барилга /зам, гүүр, худаг/ байгууламжинд хийгдсэн байна. Өнгөрсөн оны мөн үеэс барилга объектын ажил 22.2 хувиар өсөж, инженерийн барилга байгууламжийн ажил 51.1 хувиар буурсан /өнгөрсөн онд 5.9 тэрбум төгрөгийн өндөр хүчдэлийн шугамын ажил хийгдсэн/ нь нийт БУИЗА 22.3 хувиар буурахад нөлөөллөө.

БУИЗА /тэрбум төг, инфляци 24.6/



Барилгын гүйцэтгэгч ААН-үүд 2007 онд 1.6 тэрбум төгрөгийн 13 объект ашиглалтад өгч байсан бол 2008 онд 3.3 тэрбум төг-ийн ҮФ бүхий 22 объектыг ашиглалтанд оруулсан нь үндсэн фондын хэмжээ 2дахин, объектын тоо 69.2 хувиар тус тус өслөө.

ашиглалтанд оруулсан объектын тоо



Аривжих ХХК Ховд сумын 250.0 сая төгрөгийн ҮФ бүхий соёлын төвийн барилга, 450.0 сая төгрөгийн ҮФ бүхий 16 айлын орон сууц, Дэглий цагаан ХХК Улаангом сумын 95.1 сая төгрөгийн ҮФ бүхий цэцэрлэгийн объект, Малчин сумын 30.0 сая төгрөгийн ҮФ бүхий цаг уурын барилга, Амарсанаа ХХК Тэс сумын 76.0 сая төгрөгийн ҮФ бүхий ЗДТГ-ын өргөтгөлийн объект, Ундрах бүтээмж ХХК 250.0 сая төгрөгийн ҮФ бүхий Хяргас сумын Соёлын төв, Цагаан хөшөө ХХК 185.0 сая төгрөгийн ҮФ бүхий спорт заал, Мөнхийн ундраа ХХК 45.0, 45.0 сая төгрөгийн ҮФ бүхий Тариалан, Сагил сумын, 50.0 сая төгрөгийн ҮФ той Өлгий сумын ХААНБанкны контор, Увс барилга ХХК 150.0 сая төгрөгийн ҮФ бүхий Түргэн сумын спорт заал, АЗЗА ХК Өмнөговь сумын 138.5 сая төгийн ҮФ той Намирын голын гүүр, Давст сумын 92.6 сая төгрөгийн ҮФтой Торхилогийн голын гүүр, Баянмандал ХХК Өндөрхангай сумын 50.0 сая төгрөгийн ҮФ-той Боомын голын гүүр, Энержи флоу ХХК 60.0 сая төгрөгийн ҮФ-той бэлчээрийн худаг, Ус эрдэнэ ХХК 134.7 сая төгрөгийн ҮФ –той бэлчээрийн худаг, Чандмань цвс ХХК 60.0 сая төгрөгийн ҮФ бүхий цэвэр ус зөөлрүүлэх төхөөрөмж, Амори интернешнль ХХК 549.4 сая төгрөгийн ҮФ бүхий Дулааны шугам сулжээ, ББЭХС 148.0 сая төгрөгийн өртөг бүхий Улаангом тээлийн 6 квт-ын шугам, 110.0 сая төгрөгийн Тэс сумын хар үзүүрийн шугам татаж ашиглалтанд хүлээлгэж өгсөн байна.

2008 онд ашиглалтанд орсон объект


объект нэрээр	ҮФ /сая төг/
Хяргас сумын Соёлын төв	250.0
16 айлын орон сууц	450.0
Ховд сумын соёлын төв	250.0
услалтын систем	142.2
Малчин сумын цаг уур	30.0
Улаангом цэцэрлэг	95.1
Тариалан цэцэрлэг	93.9
Улаангом спорт заал	185.0
Тариалан ХААНБанк	45.0
Сагил ХААНБанк	45.0
Өлгий ХААНБанк	50.0
Тэс конторын өргөтгөл	76.0
Түргэн спорт заал	150.0
Цэвэр ус зөөлрүүлэх төхөөрөмж	150.0
Өмнөговь Намирын гол гүүр	138.5
Давст торхилогийн голын гүүр	92.6
Шинэ худаг /22/	224.7
өндөрхангай Гүүр	50.0
Дулааны шугам сулжээ	549.4
Улаангом тээлийн бквт шугам	148.0
Тэс хар үзүүрийн шугам	110.0

**Тээвэр холбоо**

Авто тээврийн салбарын аж ахуйн нэгжүүдээс Шуудангийн үйлчилгээний газар 0.3 мянган зорчигч тээвэрлэж 4102.3 мян.хүн км-ийн зорчигч эргэлт хийснийг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад зорчигчдын тоо 40.0 хувиар, зорчигч эргэлт нь 6.3 дахин буурчээ.

Нефть хангамжийн бааз 8.3 мян.тн ачаа тээвэрлэж 2809.7 мян.тн.км-ийн ачаа эргэлт хийснийг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад тээсэн ачаа нь 36.1 %-иар, ачаа эргэлт нь 24.8 хувиар өсчээ.

Нүүрс тээврийн үйл ажиллагаа эрхэлж буй Түмэнд нээлттэй хязгаарынхан хоршоо 0.3 мянган тн ачаа тээвэрлэж 796.0 мян.тн км ачаа эргэлт гүйцэтгэсэн байна.




Аймгийн Тээвэр зохицуулалтын албанаас авч буй мэдээллээр тээврийн постуудаар дамжин 67.7 мянган хүн, 67.5 мян.тн ачаа орон нутаг болон улс хооронд тээвэрлэгджээ.

Холбооны газар системээрээ 518.8 сая төгрөгийн орлоготой ажилласны 74.9 хувь нь хүн амаас орсон ба өнгөрсөн оны мөн үеэс нийт орлого нь 11.1 хувиар буурчээ.

Аймгийн бүх сумдад үүрэн телефоны операторууд үйл ажиллагаа явуулж байгаа ба өнгөрсөн оны төн үеэс CDMA ийн хэрэглэгчдийн тоо 98.5 хувиар, SKYTEL-ийн хэрэглэгчдийн тоо 59.4 хувиар, UNITEL-ийн хэрэглэгчдийн тоо 3.1 дахин, MOBICOM-ийн хэрэглэгчдийн тоо 28 хувиар тус тус өссөн байна.

Үүрэн телефон хэрэглэгчдийг харуулбал /тоо/:



**Дотоод худалдаа**

Худалдааны салбараас гол үйл ажиллагаа явуулж буй 62 нэгжийг түүвэр судалгаанд хамруулан судалж үзэхэд нэг нэгжийн сарын




борлуулалтын дундаж орлого 19.5 сая төгрөг, нэг ажиллагчийн хөдөлмөрийн бүтээмж 80.9 мянган төгрөг байна.

**Гадаад худалдаа**

Нийт экспорт 2145.1 мянган ам. доллар болж өнгөрсөн оноос 37.1 хувиар буюу 580.6 мянган ам. доллараар өссөн байна. Гол нэр төрлөөс 907.4 тн үхрийн мах, 288.1 тн адууны мах, 12 ширхэг монгол гэр, 2 ширхэг суудлын авто машин гаргаж өнгөрсөн оноос гаргасан үхрийн мах 2.7 дахин өсч, адууны мах 51.2 хувиар, монгол гэр 50 хувиар тус тус буурсан байна.

Нийт импорт 38.4 сая ам. доллар болж өнгөрсөн оноос 2.5 дахин буюу 23.2 сая ам. доллараар өссөн байна. 5911.8 тн гурил, 29.7 мянган тн нефть бүтээгдэхүүн, 23 ш авто машин, 4 ш автобус, 60,7 сая квт.цаг цахилгаан, 901.1 тн хивэг импортоор оруулсан бөгөөд өнгөрсөн оноос гурилын импорт 2.6 дахин, нефть бүтээгдэхүүний импорт 12.5 мянган тн- оор буюу 72.6 хувиар, цахилгаан эрчим хүчний импорт 7.0 мянган квт.цагаар буюу 13.0 хувиар, хивгийн импорт 840.9 тн- оор буюу 15 дахин тус тус өссөн байна. Харин авто машины импорт 47.7 хувиар буурсан байна.



**Гэмт хэрэг**

Цагдаагийн газрын мэдээгээр аймгийн хэмжээнд 2008 онд 463 гэмт хэрэг бүртгэгдсэн нь 2007 оныхоос 100 хэргээр буюу 27.5 хувиар өссөн байна. Нийт гэмт хэргийн 53.8 хувь нь Улаангом суманд үйлдэгдсэн ба дийлэнх хувийг /89/ нь өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг эзэлж байна.

Гэмт хэргийн гаралт 2007 онтой харьцуулахад Давст суманд 13.3 хувиар,

Өндөрхангай суманд 66.7 хувиар, Тариалан суманд 23.1 хувиар, Түргэн суманд 37.5 хувиар, Тэс суманд 33.3 хувиар, Цагаанхайрхан суманд 12.5 хувиар буурч бусад сумдад 14.3 хувиас 4.5 дахин нэмэгдсэн байна

2007 онтой харьцуулахад хүний амь бие, эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг 52.2 хувиар өссөний дотор хүнийг санаатай алах гэмт хэрэг 33.3 хувиар, иргэдийн эрх чөлөө, эрүүл мэндийн эсрэг хэрэг 78.9 хувиар, бусдыг амиа хорлоход хүргэх гэмт хэрэг 3.3 хувиар тус тус өсчөө.

Хүүхэд гэр бүл, нийгмийн ёс суртахууны эсрэг гэмт хэрэг 28.6 хувиар, дээрэм 75.0 хувиар, залилан 2.5 дахин, завших, үрэгдүүлэх 2.0 дахин, нийгмийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг 5.9 хувиар, хүн амын эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг 2.5 дахин, тээврийн хэрэгслийн ХАБ, ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг 31.3 хувиар тус тус өссөн байна

Мөн өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг 24.5 хувиар өссөний дотор иргэдийн өмчийн хулгай 3.8 хувиар өсчээ.

2007 онтой харьцуулахад малын хулгай 7.8 хувиар, булаалт 42.9 хувиар, бусад гэмт хэрэг 51.0 хувиар тус тус буурсан байна.

Энэ онд 402 хүн гэмт хэрэгт холбогдон шалгагдсаны 4.0 хувь буюу 16 нь эмэгтэйчүүд, 4.2 хувь нь буюу 17 нь 18 хүртлэх насны хүүхэд байна. Өнгөрсөн оноос гэмт хэрэгт холбогдсон эмэгтэйчүүдийн тоо 77.8 хувиар, 18 хүртэл насны хүүхдийн тоо 2.4 дахин өссөн байна.

Гэмт хэргийн улмаас иргэд байгууллагад 469.1 сая төгрөгийн хохирол учраад байгаа нь 2007 оноос 2.6 дахин буюу 291.5 сая төгрөгөөр өссөн байна.

Гэмт хэргийн 20.1 хувь нь согтуугаар, 14.9 хувь нь бүлэглэж үйлдэгдсэн бөгөөд 2007 онтой харьцуулахад согтуугаар үйлдэгдсэн гэмт хэрэг 25.7 хувиар, бүлэглэж үйлдсэн гэмт хэрэг 40.8 хувиар өссөн байна.


18-аас дээш насны арван мянган хүнд 99 гэмт хэрэг ноогдож өнгөрсөн оноос 23.7 хувиар өссөн бөгөөд Давст /117/, Сагил /198/, Улаангом /168/ сумдад аймгийн дунджаас 18-99 пунктээр илүү бөгөөд бусад сумдад аймгийн дунджаас 8-78 пунктээр бага байна.

Эрүүлжигдсэн хүн 1326 хүн байгаа нь 2007 оноос 330 хүнээр буюу 19.9 хувиар буурсан байна.




Шүүхээр 166 гэмт хэрэгт 267 хүн ял шийтгүүлсэн нь өнгөрсөн оноос шүүхээр таслуулсан гэмт хэрэг 21.2 хувь, шийтгүүлсэн хүний тоо 25.4 хувиар тус тус өссөн байна.

**Бүртгэгдсэн гэмт хэргийн тоо, жил бүрийн эхний 12 сараар**



**Шүүхээр таслуулсан гэмт хэрэг, ял шийтгүүлсэн хүний тоо жилийн эцсээр**



**ЦАГ УУРЫН БАЙДАЛ**

2008 оны 12-р сард агаарын дундаж температур Баруунтуруун, Тэс, Зүүнговь, Малчинд 23.7-25.9 хэм хүйтэн, хөрсний дундаж температур Тэс, Зүүнговь, Баруунтуруун, Малчин, Сагил сумдад -23.0 –ээс -26.6 хэм хүйтэн байлаа.

10 м/сек –ээс их салхитай өдөр Наранбулагт 3, Өндөрхангайд 5, Зүүнхангайд 13, Өлгийд 3, Өмнөговьд 7хоног байв. Баруунтуруунд 11, Сагилд 10, Давст 10, Зүүнхангайд 9 хоног тундастай байж нийлбэрээрээ Баруунтуруунд 12.4мм, Давстад 11.0мм, Хяргаст 14.3 мм, Зүүнхангайд 10.2мм цас орсон нь аймгийн хэмжээнд хамгийн их тундастай сумдууд болж байна.

Цасны дундаж өндөр Малчинд 16см, Улаангомд 13см, Баруунтуруун 13см, Хяргаст 14см, Өндөрхангайд 16 см байгаа нь бусад сумдаас харьцангуй илүү байна.

**УВС АЙМГИЙН СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС**